



**УЛСЫН ХОЁРДУГААР
ТӨВ ЭМНЭЛЭГ**

13381 Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг,
Энхтайваны өргөн чөлөө 49, Утас/Факс: (976) 7015 0308
И-мэйл: info@ssch.gov.mn, Вэб: www.ssch.gov.mn

2026.02.16 № 1/179

танай _____-ны № _____-т

Үнийн санал авах тухай

Тус эмнэлгийн хэвтэн эмчлүүлж буй өвчтөний хоол тасалдах эрсдэл үүссэнтэй холбоотой "Үхрийн мах" худалдан авах ажиллагааг яаралтай зохион байгуулах зорилгоор Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг үндэслэн шууд худалдан авалтын нийлүүлэлтийн үнийн саналыг авч байна.

Үхрийн мах нийлүүлэх сонирхолтой аж, ахуй нэгж байгууллагууд үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Нэн шаардлагатай Үхрийн махны үнийн саналыг 2026 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн дотор тус эмнэлгийн (info@ssch.gov.mn) цахим хаягаар болон бичгээр ирүүлнэ үү.

Хавсралт 1 хуудастай

ЗАХИРАЛ




Э.АНХБАЯР

20260240

УЛСЫН ХОЁРДУГААР ТӨВ ЭМНЭЛГИЙН ЗАХИРАЛ

БАТЛАВ

Э.АНХБАЯР



Техникийн тодорхойлолт болон стандарт

Техникийн тодорхойлолт болон стандарт

Нэр төрлийн дугаар	Бараа болон холбогдох үйлчилгээний нэр	
1	Мах	<p>1.Засгийн газрын “Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай” 2018 оны 189 дүгээр тогтоолын шаардлагад нийцсэн уут, сав, баглаа боодолтойгоор захиалагчийн захиалсан хэмжээ,тоогоор савлаж ирүүлнэ.Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:20166 хангасан байна.</p> <p>2. МУ-ын Засгийн газрын 2022 оны 224 дүгээр тогтоолоор батлагдсан “Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн зохицуулалт”-д заасан шаардлагад нийцсэн байна.</p> <p>2.1. Дээрх техникийн зохицуулалтад заасан шаардлага хангаагүй бараа нийлүүлсэн нь хүлээн авах үед мэдэгдээгүй боловч гээгээх, эвдэх, хэрэглэх явцад мэдэгдсэн тохиолдолд тухайн барааг нийлүүлэгчид буцаана. Шаардлага хангасан ижил төрлийн бараагаар шуурхай сольж өгнө.</p> <p>2.2. Мах махан бүтээгдэхүүний техникийн зохицуулалтын шаардлага хангахгүй бүтээгдэхүүн дээр хорогдол тооцуулна.</p> <p>3. Гэрээ байгуулсан нийлүүлэгч нь махыг сар тутамд мал эмнэлэгийн итгэмжлэгдсэн лабораторид шинжилгээнд хамруулж дараах үзүүлэлтүүдийг хангасан байна:</p> <ul style="list-style-type: none"> - Эрүүл ахуй, аюулгүй байдлын үзүүлэлтэд нийцсэн - Пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээнд - Малын эмийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээнд - Хүнд металлын үлдэгдлийн зөвшөөрөгдөх хэмжээнд <p>4. Нийлүүлэгчийн мах хадгалах агуулах нь MNS 5364:2011 стандартад нийцсэн байна.</p> <p>5. Хүнсний түргэн муудах эмзэг бүтээгдэхүүнийг тээвэрлэхэд тавигдах ерөнхий шаардлага MNS 5343:2011 стандартад нийцсэн байна</p> <p>6. Хүнсний бүтээгдэхүүний сав боодлын шошгололтод тавих шаардлага MNS 6648:20166 Тендерт оролцогчийн санал болгох бүтээгдэхүүн нь техникийн тодорхойлолт, эрүүл ахуйн шаардлагыг хангаж байгаа эсэхийг шалгах, турших зорилгоор тендер нээсний дараа хянан үзэх, үнэлэх шатанд тендерт оролцогчийн ажлын байр, агуулахад үнэлгээний хорооны гишүүд очиж бүтээгдэхүүн, үйлдвэрлэлтэй танилцах эрхтэй байна. Дээрх шаардлагуудыг хангаагүй бол тендерээс тагалах үндэслэл болно.</p>